НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

## НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 26 Улаанбаатар хот

| № | ХБТББ-т тусгагд-сан зорилт | Зорилтыг хэрэг-жүүлэх арга хэмжээ | Хэрэг-жүү-лэх хуга-цаа | Үндсэн хэрэг-жүүлэх бай-гуул-лага | Эх үүс-вэр | Нийт хөрөн-гийн хэм-жээ | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн | | | Хэрэгжилтийн явц | Хэрэг жил-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зорилтот түвшин, үр дүн | Төсөв сая. төг | Төсвийн гүйцэт-гэл сая. төг | | |
| Аялал жуулчлал | | | | | | | | | | | | |
| Зорилт: 3.4. Улаанбаатарын онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | | | | |
| 3.4.2 | МУХТ 3.4.9 НХТЖҮЧ 4.3.1. НЗДҮАХ 3.4.1.1. | Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдийг нэмэгдүүлнэ | 2022 | НАЖГ | Нийслэлийн төсөв | 80.0 | Жуулчны мэдээллийн төвийг Хонхор, Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудалд нээсэн. 5 байршилд 4,000 хүн мэдээлэл авсан байна. | Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийг 1-ээр нэмэгдүүлсэн байна. | 80.0 | | ХБНГУ-ын Фрэйбург хотод байрлах соёлын байранд Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийг нээн ажиллуулж байна. | 100% |
| 3.4.3 | МУХТ 3.4.9 НХТЖҮЧ 4.3.1 НЗДҮАХ 3.4.1.2. | Улаанбаатар хотын онцлог бүхий брэндийг хөгжүүлж, соёл, аялал жуулч- | 2022 | НАЖГ | Нийслэлийн төсөв | 150.0 | Аялал жуулчлалын чиглэлээр 10 үйл ажиллагаа зохион байгуулсан. | Аялал жуулчлалын чиглэлээр 12 үйл ажиллагаа зохион байгуулж, 50.000 хүн оролцсон байна. | 150.0 | | Казах түмний уламжлалт "Наурыз"-ын баярын хүрээнд Монгол Кувейтын байгаль төвд "Нүүдэлчдийн өв-Бүргэдийн баяр-2022" арга хэмжээ зохион байгуулж 5000 хүн, "Францын соёлын өдрүүд" арга хэмжээг жанжин Сүхбаатарын талбайд зохион байгуулж 2000 хүн, "Унгарын соёл, аялал жуулчлалын өдрүүд" арга хэмжээг жанжин Сүхбаатарын талбайд зохион байгуулж 5000 хүн, цахимаар шууд дамжуулалтыг 20.000 хүн, Хоспиталити-2022 арга хэмжээг Улаанбаатар зочид | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | лалын арга хэмжээг тогтмол зохион байгуул-на | | | | | | | | | буудлын үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулж 5000 хүн, "Улаанбаатар травэл экспо-2022" үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэнг Мишээл экспо төвд зохион байгуулж 7000 гаруй хүн, "Талын салхи олон улсын мото наадам"-ыг жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж 16134 гаруй мото сонирхогч залуучууд, иргэд үзэж сонирхож, шууд дамжуулалтыг 220000 гаруй хүн, Плэйтайм" олон улсын хөгжмийн наадмыг Гачуурт тосгон "Монгол шилтгээн" цогцолборт зохион байгуулж 150 гаруй хамтлаг, уран бүтээлчид өөрсдийн уран бүтээлээ 60000 гаруй хүн, "Дээлтэй Монгол Наадам-2022" арга хэмжээг жанжин Сүхбаатарын талбайд зохион байгуулж гадаад, дотоодын 10000 гаруй иргэн үзэж сонирхов. "Улаанбаатар үндэсний хоолны өдөрлөг" буюу UB Food Festival-2022 арга хэмжээг жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж 10000 гаруй хүн, "Сүүн зам" соёл, аялал жуулчлалын наадмыг жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж 25000 гаруй хүн, "Улаанбаатар" олон улсын явган аяллын фестивалийг зохион байгуулж, БНСУ, Япон, Монгол Улсын 300 гаруй алхагчид, "Солонгосын соёл, аялал жуулчлалын өдрүүд" арга хэмжээг Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж, БНСУ-аас арга хэмжээнд оролцохоор 50 гаруй уран бүтээлчид ирж, 3 өдрийн турш 10000 гаруй хүн тус тус үзэж сонирхлоо. | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.4.4 | МУХТ 3.4.9 НХТЖҮЧ 4.3.1 НЗДҮАХ 3.4.1. | Аялал жуулчлалын бааз болон худалдаа үйлчилгээний байгууллагуудын ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлагад нийцүүлнэ | 2022 | НАЖГ | Нийслэлийн төсөв | - | Ариун цэврийн байгууламжийг стандарт хангуулах шийдвэр | Жуулчны бааз, амралтын газар болон худалдаа үйлчилгээний байгууллагуудын ариун цэврийн байгууламжийг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлнэ | - | | Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэж буй амралтын газар, жуулчны баазуудад MNS 6043:2019 стандартыг хэрэгжүүлэх заавар зөвлөгөөг өгч, нийт амралтын газар, жуулчны баазууд стандартын шаардлагад нийцсэн жорлонг ашиглаж байгаа. Мөн "Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 11 дүгээр албан даалгаврын хүрээнд Усны газар, Туул голын сав газрын захиргаа, Горхи-тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа хамтран усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавих, хамгаалалтын бүсэд байгаа стандартын шаардлага хангаагүй нүхэн жорлонг буулгаж, бүх байршилд газар шорооны ажил, төмөр бетон КС-1500 кольцо суурилуулах, ус чийгээс хамгаалах түрхлэг түрхэх, бетонон ул цутгах, төмөр бетон таг байрлуулж буцаан булах ажил бүрэн хийгдсэн. | 100% |
| 3.4.5 | МУХТ 3.4.9 НХТЖҮЧ -4.3.1 НЗДҮАХ-3.4.1. | Гадаад дотоодын жуулчдын татах хотын аяллын шинэ бүтээгдэхүүнийг 2-оор нэмэгдүүлнэ. | 2022 | НАЖГ | Нийслэлийн төсөв | 80.0 | Хотын аяллын шинэ бүтээгдэхүүнийг 1-ээр нэмэгдүүлсэн. | Хотын аяллын шинэ бүтээгдэхүүнийг 2-оор нэмэгдүүлсэн байна. | 80.0 | | - Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэр Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булш, цогцолборыг байгуулан авто машины зогсоол, гадна хашаа, ариун цэврийн байгууламж, мод бут суулгах ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>- Их тэнгэрийн амны хадны зургийн орчныг тохижуулах ажлын хүрээнд 12 авто машины зогсоол, явган хүний чулуун зам, чулуун шат, шатны бариул, тавцан, тавцангийн хашилт, сүүдрэвч зэргийг хийж, хадны зургийн тайлбар мэдээлэл бүхий самбар байршуулан, мод бут тарьж тохижуулах ажлыг хийж гүйцэтгэв. | 100% |
| 3.4.6 | МУХТ 3.4.9 НХТЖҮЧ -4.3.1 | Улаанбаатар хотын онцлог | 2022 | НАЖГ | Нийслэлийн төсөв | 20.0 | Улаанбаатар брэндийн 6 шинэ | Улаанбаатар брэндийн бүтээгдэ- | 20.0 | | "Кью Эн Эс" ХХК-ний Хөсөг төсөлтэй хамтран Улаанбаатар брэнд лого, өнгө дизайн, уриа үг бий болгосон. Хөсөг брэндийн эсгий урлал, Тэрэн брэнд модон, | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | НЗДҮАХ-3.4.1. | бүхий брэндийг хөгжүүлж, бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан сурталчилна | | | | | бүтээгдэхүүн бий болгосон. | хүүнийг 3-аар нэмэгдүүлнэ. | | | шилэн материалаар хийгдсэн тоглоом бэлэг дурсгалын бүтээгдэхүүн, Мери марта жуулчдад зориулсан гар урлалын бүтээгдэхүүн, сав баглаа боодол нийт 10 төрлийн загвар бүтээгдэхүүн бий болгосон. Брэнд бүүкээр 31 төрлийн бүтээгдэхүүнд "Visit Ulaanbaatar" логог байршуулахаар тогтов. | |
| 3.4.7 | МУХТ 3.4.9 НХТЖҮЧ -4.3.1 НЗДҮАХ-3.4.1. | Богдхан уулын дархан цаазат газрын явган аяллын маршрутын зураг төсвийг боловсруулна | 2022 | НАЖГ | Улсын төсөв | 400.0 | - | Зураг, төсвийг боловсруулсан байна. | 400.0 | | Богдхан уулын дархан цаазат газрын явган аяллын маршрутын зураг төсөв боловсруулах ажлын даалгаварт санал тусган БОАЖЯ-нд хүргүүлсэн. БОАЖЯ зураг, төсвийн ажлыг гүйцэтгэж байгаа болно. | 100% |
| 3.4.8 | МУХТ 3.4.9 НХТЖҮЧ -4.3.1 НЗДҮАХ-3.4.1. | Улаанбаатар хот орчмын түүх соёлын дурсгалыг түшиглэн хөгжүүлж, аяллын эргэлтэд оруулна | 2022 | НАЖГ | Нийслэлийн төсөв | 110.0 | Нийслэлийн түүх, соёлын 47 газрын судалгаа хийж 5 байршилд хамгаалалтын бүс тогтоохоор сонгон авсан | Шинээр 2 бүтээгдэхүүн нэмэгдүүлсэн байна. | 110.0 | | - Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэр Бэлхийн амны Хүннүгийн язгуууртны булш, цогцолборыг байгуулан авто машины зогсоол, гадна хашаа, ариун цэврийн байгууламж, мод бут суулгах ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>- Их тэнгэрийн амны хадны зургийн орчныг тохижуулах ажлын хүрээнд 12 авто машины зогсоол, явган хүний чулуун зам, чулуун шат, шатны бариул, тавцан, тавцангийн хашилт, сүүдрэвч зэргийг хийж, хадны зургийн тайлбар мэдээлэл бүхий самбар байршуулан, мод бут тарьж тохижуулах ажлыг хийж гүйцэтгэв. | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.4.9 | МУХТ.3. 4.9 НХТЖҮЧ 4.3.1 НЗДҮАХ 3.4.1 | Авто машин-гүй гудамж арга хэмжээ зохион байгуу-лах /Өглөө-ний гудамж, аялал жуулчла-лын гудамж, Санхүү-гийн гудамж/ | 2022 | НАЖГ | Нийс-лэлийн төсөв | 1.400 .0 | Өглөөний гудамж байгуулсан. | “Аялал жуулчлал ын гудамж” “Санхүү-гийн гудамж” арга хэмжээг зохион байгуулж үйл ажилла-гааг 100% нээнэ. | 1.400.0 | | Улаанбаатар хотод соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, чөлөөт уран бүтээлчдийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын цогцолбор бий болгох зорилгоор Сүхбаатар дүүрэгт байрлах Үндэсний соёл амралтын хүрээлэнд “Метро стрийт” гэрэлт гудамжны тохижилтын ажлын зураг төсөлд санал тусгаж Нийслэлийн Хот тохижилтын газарт хүргүүлсэн. | 100% |
| 3.4.10 | МУХТ 3.4.9 НХТЖҮЧ -4.3.1 НЗДҮАХ-3.4.2. | Олон улсад Улаан-баатар хотыг сурталч-лан таниулах дүрс бичлэг бүхий аялал жуулч-лалын контент бэлтгэж, цахим аялал жуулч-лалыг хөгжүүл-нэ | 2022 | НАЖГ | Нийс-лэлийн төсөв | 10.0 | Аялал жуулчлалын 2 контент бэлтгэж, 20.000 хүн үзсэн байна. | Аялал жуулчлал ын 2 контент бэлтгэж, 30.000 хүн үзсэн байна. | 10.0 | | Сити оф номадс, Дээлтэй монгол, Улаанбаатар трэвел экспо, Хорека зочид буудал зоогийн газрын хангамжийн үзэсгэлэн, “Хотын аяллын” влог, Сити тур хотын аяллаар “Том ахын аялал” нэвтрүүлэг 2, “Generation” нэвтрүүлэг, “Сүүн зам” олон улсын бүжгийн наадам, “Даншиг наадам хүрээ цам наадам”, “Юби фоод” олон улсын хоолны өдөрлөг Арт гэр олон орны хоолны влог, “KBS” солонгосын телевизтэй хамтран Монгол улс Улаанбаатар хотыг сурталчлах нэвтрүүлэг зэрэг нийт 12 контент бэлтгэж www.tourism.ub.gov.mn цахим хуудсанд 20,000, www.visitulaanbaatar.net цахим хуудсанд 25,406, Нийслэлийн Аялал жуулчлалын газар пэйж хуудсанд 747,000 нийт 792,406 гаруй хүн үзсэн байна. | 100% |
| 3.4.11 | МУХТ 3.4.9 | Нийс-лэлд үйл ажил- | 2022 | НАЖГ | Нийс-лэлийн төсөв | - | 100 аж ахуйн нэгж | 200 аж ахуйн нэгж | - | | -“Байрших үйлчилгээний салбар дахь цахим шилжилт” сургалтыг 04 дүгээр сарын 19-22-ны өдрүүдэд цахимаар зохион | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | НХТЖҮЧ -4.3.1 НЗДҮАХ-3.4.2.. | лагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амрал-тын газар, жуулчны баазуу-дыг цахим хэлбэ-рээр урьдчил-сан захиалга авах системд холбо-ход дэмжин ажил-лана | | | | | | хамруул-сан байна | | | байгуулж 6 дүүргийн зочид буудлын 120 хүн,<br>-“Хотын стандартыг мөрдүүлэх, сурталчлах, зочлох үйлчилгээний салбарын чиг хандлага, үйлчилгээний чанар, үйл ажиллагааг сайжруулах нь” сургалтад 190 хүн нийт 2 удаагийн сургалтад 310 хүнийг хамруулав. | |
| 3.4.12 | МУХТ 3.4.9 НХТЖҮЧ -4.3.1 НЗДҮАХ-3.4.2. | Улаанба атар хотыг олон улсын аялал жуулчла-лын үзэсгэлэ нгүүдэд оролцож ,сурталч-лан | 2022 | НАЖГ | Нийс-лэлийн төсөв | - | Нийт 4 олон улсын чанартай үзэсгэлэн, арга хэмжээнд оролцсон. | Олон улсын чанартай 6 үзэсгэлэнд оролцсон байна. | | - | - Ай Ти Би Берлин үзэсгэлэн виртуал орчинд цахимаар зохион байгуулагдаж 464 хүнд,<br>- “Улаанбаатар травэл экспо-2022” үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэнг зохион байгуулж 106 байгууллага 7000 иргэнд,<br>- Япон улсын Токио хотноо зохион байгуулагдсан “ЖАТА” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцож сурталчилгааны материал 330 ширхгийг,<br>- “Ай Ти Эм-2022" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд “Ub winter sale” төсөл, /www.ubwinter.com/-ийг олон нийтэд танилцуулж, Жуулчны мэдээлэл | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | таниул-на. | | | | | | | | | сурталчилгааны цэгийг ажиллуулж 15.000 гаруй иргэд, жуулчдад мэдээлэл өгч<br>- БНСУ-ын Сөүл, Бусан, Чонжү хотуудад Монголын аялал жуулчлалын сурталчилгаа, танилцуулга арга хэмжээг зохион байгуулж 1100 ширхэг,<br>- Япон улсын Токио, Осака хотуудад Монголын аялал жуулчлалын сурталчилгаа, танилцуулга арга хэмжээг зохион байгуулж 1100 ширхэг нийт 2200 ширхэг сурталчилгааны материал тараав.<br>- Дэлхийн хотуудын Аялал жуулчлалын холбоонд элсэж 2022 оны 06 дугаар сарын 03-ний өдөр "Батламж" хүлээн авсан.<br>- "Цайны зам" олон улсын аялал жуулчлалын холбооны гишүүн орнуудын хурал 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдөр цахимаар зохион байгуулагдаж Монгол, БНХАУ, ОХУ-ын аялал жуулчлалын сайд, гишүүн орны хотуудын 200 гаруй төлөөлөл оролцов.<br>Нийт олон улсын 8 арга хэмжээнд оролцсон. | |
| 3.4.13 | МУХТ 3.4.9 НХТЖҮЧ -4.3.1 НЗДҮАХ-3.4.3. | Жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчи-лан сэргий-лэх, чиглэ-лээр арга хэмжээ зохион байгуулж сурталч-лах, контент, санамж, гарын авлага | 2022 | НАЖГ | Нийс-лэлийн төсөв | - | Жуулчдын аюулгүй байдлыг хангах, чиглэлээр 4 арга хэмжээ зохион байгуулсан | Жуулчдын аюулгүй байдлыг хангах, чиглэлээр 5 арга хэмжээ зохион байгуул-сан байна. | - | | - "Оюутан цагдаа-2022" арга хэмжээг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Монголын Оюутны холбоотой хамтран 2022 оны 06 дугаар сарын 20-ноос 08 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл хугацаанд жуулчдын ихээр зорчдог гудамж талбай, олон нийтийн газруудад Үндэсний их баяр наадам болон бусад арга хэмжээнүүдэд нийт 150 оюутан үүрэг гүйцэтгэв.<br>- Жуулчны аюулгүй байдлын контентийг жуулчид хүлээн авдаг зочид буудлууд, агаарын хөлгийн бүхээгт байршуулж ажиллахаар Агаарын тээврийн компаниудтай санамж байгуулав.<br>- Жуулчны аюулгүй байдлын санамжийг жуулчны мэдээллийн төвүүд болон жуулчдад зориулсан арга хэмжээнүүдийн үеэр 5000 ш тараасан.<br>- Жуулчны баазын үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах сургалтыг Аялал жуулчлалын ур чадварын мэргэжил | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бэлтгэж тараана. | | | | | | | | | сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран 2022 оны 06 дугаар сарын 06-10-ны өдрүүдэд зохион байгуулж 40 жуулчны баазын удирдлагыг хамруулав.<br>“Хотын стандартыг мөрдүүлэх, сурталчлах, зочлох үйлчилгээний салбарын чиг хандлага, үйлчилгээний чанар, үйл ажиллагааг сайжруулах нь” сургалтад 190 хүн,<br>Нийт 5 арга хэмжээ зохион байгуулав. | |
| 3.4.14 | МУХТ 3.4.9 НХТЖҮЧ-4.3.1 НЗДҮАХ-3.4.3. | Нийслэлийн нутаг дэвсгэрт зочлох үйлчилгээ-ний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад стандартын үзлэг шалгалт зохион байгуулж нэгдсэн мэдээллийн санг шинэчлэн бүртгэлжүүлнэ | 2022 | НАЖГ | Нийслэлийн төсөв | 20.0 | 500 аж ахуйн нэгж | 700 аж ахуйн нэгжийг бүртгэсэн байна | 20.0 | | 2022 оны байдлаар Онлайн бизнес төв”-д нийт 454 аж ахуйн нэгж зочид буудал, дэн буудал, амралтын газрын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан байна. Үүнээс шийдвэрлэсэн-174, шилжүүлсэн-254, татгалзсан-3, буцаасан-23 гэсэн төлөвтэй байна. | 100% |
| 3.4.15 | МУХТ 3.4.9 | Нийслэлд үйл ажил- | 2022 | НАЖГ | | - | Нийслэл хотын албан | Нийслэл хотын | - | | Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хороо”-ны 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 03 дугаар тогтоолын 1.5 дахь | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | НХТЖҮЧ -4.3.1 НЗДҮАХ-3.4.3 . | лагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад тавигдах ерөнхий шаардлагад нэмэлт оруулах замаар и-баримтад бүрэн холбож, нийслэл хотын албан татвараас төвлөрөх орлогыг нэмэгдүүлнэ. | | | Нийслэлийн төсөв | | татвараас 7,345.3 мянган төгрөг төвлөрсөн. | албан татвараас нийслэлийн төсөвт 9,000.0 мянган төгрөг төвлөрсөн байна. | | | заалтын дагуу Аялал жуулчлалын салбарт мөрдөгдөж буй үйлчилгээний стандартуудыг шинэчлэх, олон улсын жишигт нийцүүлэн шинээр стандартуудыг боловсруулан батлуулах дэд ажлын хэсэгт “Зочид буудлын ерөнхий шаардлага MNS 4588:2008”, “Аялал жуулчлал. Дэн буудлын ерөнхий шаардлага MNS 5738:2007”, “Амралтын газар, жуулчны баазын ерөнхий шаардлага MNS 4963:2019” стандартуудыг шинэчлэн саналаа хүргүүлсэн. Стандартын төсөлд зочин бүртгэлийн программыг и-баримтад холбосон байх шаардлагыг тусгасан. Нийслэл хотын албан татвараас 2022 оны 11 сарын байдлаар 10.840.294.800 төгрөг төвлөрүүлэв. | |
| 3.4.16 | МУХТ 3.4.9 НХТЖҮЧ -4.3.1 НЗДҮАХ-3.4.3. | Аялал жуулчлалын салбарын ажилтнуудын ур чадварыг дээшлүү | 2022 | НАЖГ | Нийслэлийн төсөв | - | 450 хүн хамруулсан | 450 хүн хамруулна | - | | -“Байрших үйлчилгээний салбар дахь цахим шилжилт” сургалтыг 04 дүгээр сарын 19-22-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулж 6 дүүргийн зочид буудлын 120 хүн,<br>-Зочин хүлээн авагч, Өрөө үйлчилгээ, Зөөгч, Бартендер мэргэжлийн сургалтад 41 хүн, | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | -лэх, олон улсын туршлагыг судлах, экспертийг урьж төрөлжсөн сургалтуудыг зохион байгуулна. | | | | | | | | | - Жуулчны баазын үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах нь сургалтад 40 жуулчны баазын удирдлага,<br>- “Оюутан цагдаа-2022” арга хэмжээний сургалтад 150 оюутан,<br>- “Хотын стандартыг мөрдүүлэх, сурталчлах, зочлох үйлчилгээний салбарын чиг хандлага, үйлчилгээний чанар, үйл ажиллагааг сайжруулах нь” сургалтад 190 хүн,<br>- Их түүхийн жимээр аяллын боловсрол олгох сургалтад ЕБС-ийн 90 сурагч,<br>- Хөтөчийн Ур чавдарын сургалтад 34 хүн,<br>- “Чингис хааны музейг хэрхэн тайлбарлах” сургалтад 50 хөтөч тайлбарлагч хамрагдлаа. Нийт 7 удаагийн сургалтаар 715 хүн хамруулав. | |
| 3.4.17 | МУХТ 3.4.9 НХТЖҮЧ -4.3.1 НЗДҮАХ-3.4.3. | Хорека зочид буудал, зоогийн газрын үзэсгэлэн, зочлох үйлчилгээний салбарын мэргэжлийн аварга шалгаруулах олон улсын тэмцээнийг зохион байгуулна | 2022 | НАЖГ | Нийслэлийн төсөв | 50.0 | 84 аж ахуйн нэгж | 50 аж ахуйн нэгжийг үзэсгэлэнд хамруулж 30 хүнийг тэмцээнд хамруулсан байна. | 50.0 | | Зочид буудал, зоогийн газрын хангамжийн үзэсгэлэнг 2022 оны 5 дугаар сарын 13,14-ны Улаанбаатар зочид буудлын Их танхимд зохион байгуулж 45 байгууллага бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчилж оролцов. Арга хэмжээний үеэр салбарын хүний нөөцийг чадавхжуулах, туршлага солилцох, ажил мэргэжлийг сурталчлах зорилгоор “Зочлох үйлчилгээний салбарын ажил мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээн”-ийг зохион байгуулж, 2 дугаар шат буюу шилдэг шалгаруулалтад Бишрэлт, Сан, Холидэй инн, Ибис, Аврора, Рамада, Миллениум зочид буудал, Рэдрок ресорт, Номадс Хоспиталити ХХК, Ханбүргэд зочид буудал /Хэнтий аймаг/, Онцгой жаргалант амралт, сувилал зэрэг байгууллагын 40 гаруй ажилтан Зочин хүлээн авагч, Өрөө үйлчилгээ, Зөөгч, Бартендер ажил мэргэжлээр оролцлоо. | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.4.18 | МУХТ 3.4.9 НХТЖҮЧ -4.3.1 НЗДҮАХ-3.4.4. | "Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ"-г боловсруулж хэрэгжүүл-нэ. | 2022 | НАЖГ | Нийслэлийн төсөв | - | Аялал жуулчлалыг хөгжүүлэх цогц бодлого шаардлагатай | "Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ"-г боловсруулж хэрэгжүүлнэ. | - | | Нийслэлийн аялал жуулчлалыг 2021-2025 онд хөгжүүлэх 4 жилийн арга хэмжээний төслийг Үндэсний хөгжлийн газар, салбарын мэргэжлийн холбоодтой хамтран боловсруулж, арга хэмжээний төслийн төсөлд холбогдох төрийн байгууллагууд болон салбарын байгууллагуудаас санал авч нэгтгэн Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Улаанбаатар хотын аялал жуулчлалыг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/599 дүгээр захирамжаар батлуулсан. Арга хэмжээний 7 зорилтын 77 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 90% |
| 3.4.19 | МУХТ 3.4.9 НХТЖҮЧ -4.3.1 НЗДҮАХ-3.4.4. | Нийслэлд аялал жуулчлалыг хөгжүүлэх нөөц даацын судалгаа, жуулчдын сэтгэл ханамжийн судалгаа, эдийн засаг, нийгэм, соёл, байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн судалгааг хийнэ | 2022 | НАЖГ | - | - | - | 4 төрлийн судалгаа хийсэн байна. | | | Нийслэлд аялал жуулчлалыг хөгжүүлэх нөөц даацын судалгаа, жуулчдын сэтгэл ханамжийн судалгаа, эдийн засаг, нийгэм, соёл, байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн судалгааг БОАЖЯ-ны санхүүжилтээр хамтран зохион байгуулахаар гэрээнд тусгагдсан боловч тус судалгааны санхүүжилтийг шийдвэрлэээгүйн улмаас хийгдээгүй болно.<br>Тус газраас өөрсдийн санаачилгаар Санхүү эдийн засгийн сургуультай хамтран Аялал жуулчлалын салбарт нөлөөлж буй бизнесийн орчны тодорхойгүй нөхцөл байдлууд оролцогч талуудын уялдаа холбоо, хамтын стратегид хэрхэн нөлөөлж буйг тодорхойлон өнөөгийн хамтын стратегийн түвшинийг хэмжих, цаашид хөгжүүлэх боломжит хувилбарыг санал болгох зорилгоор 5 хэсэг бүхий (1-р хэсэг Аялал жуулчлалын салбарын зах зээл, 2-р хэсэг Инноваци буюу Технологи, 3-р хэсэг Шууд болон шууд бус өрсөлдөгчидтэй хамтран ажиллах, 4-р хэсэг Төр засаг, хууль эрх зүйн орчны талаар, 5-р хэсэг Ерөнхий мэдээллийн хэсэг) сонгох тесттэй 64 асуулт, нээлттэй буюу бичих 2 зэрэг нийт 66 асуулттай боловсруулан Улаанбаатар хот болон 21 аймагт үйл ажиллагаа эрхэлж буй амралтын газар, жуулчны баазуудын захирал болон | 90% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | менежерүүдээс цахимаар /линк/ болон цаасаар судалгааг авч байна. Мөн жуулчдын сэтгэл ханамжийн судалгаа, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой судалгааг авч нэгтгэж байна. | |
| 3.4.20 | МУХТ 3.4.9 НХТЖҮЧ-4.3.1 НЗДҮАХ-3.4.4. | Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ. | 2022 | НАЖГ | - | | Цар тахлын дараа аялал жуулчлалыг хөгжүүлэх цогц төлөвлөгөө шаардлагатай | Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээх хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. | | | "Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г Монгол Улсын Засгийн газрын "Шинэ сэргэлтийн бодлого"-той уялдуулан боловсруулж, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Аялал жуулчлалын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн баталж, хэрэгжилтийг хангаж байна. | 90% |
| ДҮН | | | | | | | | | | | | 98% |

ТАНИЛЦСАН: ДАРГА Д.БАТСҮХ

ХЯНАСАН: ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Х.СОДНОМДЭМБЭРЭЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН: ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ, СТАТИСТИК СУДАЛГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ч.ЭНХ-ОТГОН

НЭГТГЭСЭН: БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТАЙЛАН, СУРГАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э.МӨНХЗУЛ

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 26 Улаанбаатар хот

| № | Шалгуур үзүүлэлт | Хэм-жих нэгж | Үндсэн хэрэг-жүүлэх байгууллага | Суурь түвшин | Зорилтод түвшин | Хүрсэн түвшин | Хэрэг-жил тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Аялал жуулчлал | | | | | | | |
| Зорилт: 3.4. Улаанбаатарын онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| 3.4.2 | Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвөөр мэдээлэл авсан хүн | Тоо | НАЖГ | 4000 | 1-ээр нэмэгдүүлсэн байна | 1-ээр нэмэгдүүлсэн | 100% |
| 3.4.3 | Аялал жуулчлалын чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцогчид | Тоо | НАЖГ | 45.000 | 50.000 | 523.750 | 100% |
| 3.4.4 | Стандартын шаардлагад нийцүүлсэн ариун цэврийн байгууламж | Тоо | НАЖГ | Ариун цэврийн байгууламжийг стандарт хангуулах шийдвэр | Үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлнэ | Стандартын шаардлагад нийцсэн жорлонг ашиглаж байна. | 100% |
| 3.4.5 | Хотын аяллын шинэ бүтээгдэхүүний тоо | Тоо | НАЖГ | 1-ээр нэмэгдүүлсэн. | 2-оор нэмэгдүүлсэн байна. | 3-оор нэмэгдүүлсэн | 100% |
| 3.4.6 | Улаанбаатар хотын онцлог бүхий брэндийг нэмэгдүүлсэн тоо | Тоо | НАЖГ | 6 шинэ бүтээгдэхүүн бий болгосон. | 3-аар нэмэгдүүлнэ. | 10-аар нэмэгдүүлсэн | 100% |
| 3.4.7 | Зураг, төсвийг боловсруулах | Тоо | НАЖГ | - | Зураг, төсвийг боловсруулсан байна | Санал хүргүүлсэн | 100% |
| 3.4.8 | Нийслэлийн түүх соёлын дурсгалыг аяллын эргэлтэд оруулах | Тоо | НАЖГ | 47 газрын судалгаа хийж 5 байршилд хамгаалалтын бүс тогтоохоор сонгон авсан. | Шинээр 2 бүтээгдэхүүн нэмэгдүүлсэн байна. | 2 бүтээгдэхүүн нэмэгдүүлсэн | 100% |
| 3.4.9 | Авто машингүй гудамж | Тоо | НАЖГ | Өглөөний гудамж байгуулсан. | "Аялал жуулчлалын гудамж", "Санхүүгийн гудамж" арга хэмжээг зохион байгуулж, үйл ажиллагаа 100% нээнэ | Санал хүргүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.4.10 | Контент бэлтгэх, үзсэн хүн | Тоо | НАЖГ | Аялал жуулчлалын 2 контент бэлтгэж, 20.000 хүн үзсэн байна. | 2 контент бэлтгэж, 30.000 хүн үзсэн байна. | 12 контент бэлтгэж 792,406 гаруй хүн үзсэн | 100% |
| 3.4.11 | Цахимаар урьдчилсан захиалга авах системд холбогдсон байгууллага | - | НАЖГ | 100 аж ахуйн нэгж | 200 аж ахуйн нэгж хамруулсан байна | 310 аж ахуйн нэгж хамруулсан | 100% |
| 3.4.12 | Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн. | Тоо | НАЖГ | Нийт 4 олон улсын чанартай үзэсгэлэн, арга хэмжээнд оролцсон. | Олон улсын чанартай 6 үзэсгэлэнд оролцсон байна. | 6 арга хэмжээ зохион байгуулсан | 100% |
| 3.4.13 | Жуулчдын аюулгүй байдлын контент, санамж, гарын авлага | Тоо | НАЖГ | 4 арга хэмжээ зохион байгуулсан | 5 арга хэмжээ зохион байгуулсан байна. | 5 арга хэмжээ зохион байгуулсан | 100% |
| 3.4.14 | Мэдээллийн санд хамрагдсан байгууллагын тоо | Тоо | НАЖГ | 500 аж ахуйн нэгж | 700 аж ахуйн нэгжийг бүртгэсэн байна | 454 аж ахуйн нэгжийг бүртгэсэн | 100% |
| 3.4.15 | Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудаас, нийслэл хотын албан татварт төвлөрөх орлого | - | НАЖГ | 7.345.3 мянган төгрөг | 9,000.0 мянган төгрөг төвлөрсөн байна. | 10.840.294.800 төгрөг төвлөрсөн | 100% |
| 3.4.16 | Сургалтад хамрагдсан ажилтнуудын тоо | Тоо | НАЖГ | 450 хүн хамруулсан | 450 хүн хамруулна | 715 хүн хамруулав | 100% |
| 3.4.17 | Арга хэмжээнд оролцогчид | Тоо | НАЖГ | 84 аж ахуйн нэгж | 50 аж ахуйн нэгжийг үзэсгэлэн, 60 хүнийг тэмцээнд хамруулсан байна. | 45 байгууллага 41 хүн оролцлоо. | 100% |
| 3.4.18 | "Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ"-ний хэрэгжилт | Хувь | НАЖГ | - | "Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ"-г боловсруулж хэрэгжүүлнэ. | 7 зорилтын 77 арга хэмжээ тусгагдсан бөгөөд хэрэгжүүлж эхлээд байна. | 90% |
| 3.4.19 | Нөлөөллийн судалгаа | Тоо | НАЖГ | - | 4 төрлийн судалгаа хийнэ | 3 төрлийн судалгаа хийсэн | 90% |
| 3.4.20 | Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ. | - | НАЖГ | - | Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээх хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. | Төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлж байна. | 90% |
| ДҮН | | | | | | | 98% |

ТАНИЛЦСАН: ДАРГА D.Batsu Д.БАТСҮХ

ХЯНАСАН: ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Х.СОДНОМДЭМБЭРЭЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН: ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ, СТАТИСТИК
СУДАЛГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Ч.ЭНХ-ОТГОН

НЭГТГЭСЭН: БОДЛОГЫН БАРИМТ
БИЧГИЙН ТАЙЛАН, СУРГАЛТ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э.МӨНХЗУЛ